

Ч.Оюунбилэг, В.Энхжаргал, Ж.Ууганцэцэг
Х.Энхжаргал, С.Баасандулам, Д.Энхжаргал

ХӨГЖИМ

I

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
1 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Зургаа дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

DDC
371.32
X-545

Хөгжим I: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 1 дүгээр ангийн сурах бичиг /Оюунбилэг Ч., ба бус; Ред. Бүдхүү Х. -УБ. 2014.-68х

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан тул Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-63-5

ГАРЧИГ

Хөгжилтэй агшин	5	Өөрийгөө сориорой	37
Яагаад	6	Хичээлийн завсарлагааны дуут бүжиг	38
Номын нөхөр болоорой	6	Эрдмийн үсэг сурлаа	39
Харсан бас сонссон	7	Бага ангийн багшдаа баярлалаа	40
Байгалийн дуу чимээ	8	Дүүдээ хэлж өгнө дөө	41
Хөгжилтэй аялал	10	Марш	42
Сонор чих	12	Полька	42
Навчис	17	Бүүвэйн дуу	42
Далай	18	Хагас ноот	44
Цэвэр гар	19	Бүтэн ноот	47
Үлгэр зохиоё	21	Цасан хүн	49
Өөрийгөө сориорой	23	Хүүхэлдэй	50
Би дуучин	24	Бөмбөрчин	51
Дэлхийгээ би мэднэ	24	Өөрийгөө сориорой	54
Хувиршгүй тоолол	25	Яргуй дэлгэрлээ	55
Мөнх ногоон гацуур	25	Сайн уу, муу юу аль нь вэ?	56
Марш	26	Шүдээ хайрлая	57
Амьтдын марш	27	Вальс Глинка.М	58
Вальс Штраус.И	27	Ярилцсан нь	59
Дөрөвт ноот	28	Шүдээ угаацгаая	63
Наймт ноот	29	Яргуй дэлгэрлээ	64
Ангаахай	32	Хавар	65
Алга ташиж тоглоцгооё	33	Өөрийгөө сориорой	68
Туулай, зараа хоёр	36		

ӨМНӨХ ҮГ

Сургуулийн сурагч болсон бяцхан багачууддаа баяр хүргэе.

Хүүхдүүд та нар хөгжмийн хичээлээр олон сайхан дуу дуулж, хөгжим сонсоно. Бас хөгжмийн аясаар бүжиглэж, хүүхдэд зориулсан бяцхан зэмсгүүдээр хөгжимдөж сурна.

Хөгжмийн сурах бичигт та нарын сурах дуу, бүжиг, сонсох хөгжим, хийж гүйцэтгэх дасгал даалгаврууд орсон байгаа. Тэдгээрийн зураг, ноотыг сайтар ажиглаж, багш болон аав ээжийнхээ тусламжтайгаар мөн биеэ дааж сурч эзэмшээрэй.

Байгаль, ургамал, ан амьтан, найз нөхөд, аав ээжээ хайрлах хайр, дуу хөгжимд шингэсэн байдгийг олж мэдээрэй. Шувуудын жиргээн, мал амьтдын дуу чимээ, навчсын сэрчигнээн, гол усны шуугиан, шаагин орох бороо зэрэг хөгжим мэт байгалийн элдэв дуу чимээ, тэдгээрийг дүрсэлсэн хөгжмийн бүтээлийг сонсож таницгаая.



БИД ЮУ СУРАХ ВЭ?



ТАНИХ ТЭМДЭГ



ДУУЛЪЯ



СОНСЪЁ



ХӨГЖИМДЪЕ



БҮЖИГЛЭЕ



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ



ДУУЛЪЯ

БИ ГОЁ ХАРАГДАЖ БАЙНА УУ?

Тоглоом тоглоцгоёе. Тэгшхэн зогсож нуруугаа цэх байлгаарай. Жижиг хүүхэлдэй эсвэл ном толгой дээрээ тогтоож, багшийгаа арав хүртэл тоолох хугацаанд цэх зогсоно. Амьсгаагаа гүнзгий авч аажмаар зөөлөн гаргаарай.



ХӨГЖИЛТЭЙ АГШИН

“Гоёо гоё” дууг та нар жаахан байхаасаа л дуулж сурсан. Харин одоо илүү хөгжилтэй байдлаар дуулцгаая. “бишээ”, “угаая”, “аан” гэдэг үгүүдийг дуулахгүй зөвхөн хөдөлгөөнөөр илэрхийлнэ шүү. Зөв дуулахын тулд анхааралтай байгаарай.

Чигчийхэн чинээ.....

Чихээ өөрөө.....

Тиймээ хө.....



Гоёо гоёо гоёо



- Багшийгаа сонсоод, дагаад дуулаарай.

Үг. Ц.Баянтунгалаг

Ая. Б.Цэвээнсүрэн

ЯАГААД

Удаан

7

Нав-чин дээр яа - гаад су - дал бай-даг вэ? На - мар яа - гаад
 шу-вууд буц-даг юм бэ? яа - гаад яа - гаад яа - сан со - нин юм бэ?



v амьсгаа авах тэмдэг.

Дуу яагаад намайг уяраана вэ?
 Дэгдээхэй яагаад нисэж чаддаггүй юм бэ?
 Яагаад? Яагаад?
 Яасан сонин юм бэ?

Үг. Ж.Дашдондог

Ая.Б.Цогоо

НОМЫН НӨХӨР БОЛООРОЙ

Дунд зэрэг

5

О - юун бил-гийн ал - тан түл-хүүр Онц сур - ла - гын а - риун унд - раа
 Ном ном ун - шаа - рай Но - мын нө - хөр бо - лоо - рой

Оюун билгийн
 Алтан түлхүүр
 Онц сурлагын
 Ариун ундраа
 Ном, ном уншаарай
 Номын нөхөр болоорой

Аяны замд
 Дотны найз
 Амьдралын замд
 Мэргэн багш




||: :|| Энэ хэсгийг дахиж дуулна.



- Багшийгаа сонсоод, дагаад дуулаарай.
- Юу харснаа хөдөлгөөнөөр дүрслэн харуулаарай.
- Юу сонссоноо дуу авиагаар илэрхийлээрэй.

ХАРСАН БАС СОНССОН



Хар - сан хар - сан юу хар - сан бэ?
Сонс - сон сонс - сон юу сонс - сон бэ?





СОНСЪЁ




БАЙГАЛИЙН ДУУ ЧИМЭЭ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Юуны чимээ болохыг тодорхойлцгооё.
- Сонссон дуу чимээгээ дуурайн тоглоорой.





Бид дуу чимээний
ертөнцөд амьдардаг. Бид
түүнийг сонсож таньдаг.




ХӨГЖИЛТЭЙ АЯЛАЛ

- Зургийг ажиглаарай. Ямар дуу чимээ гарах вэ?
- Хөгжмөө сонсоод байгалийн дуу чимээг тодорхойлоорой.






- Анхааралтай сонсоорой.
- Шувуудын дууг сонсоод, тодорхойлцгооё. Таньсан дарааллаараа дугаарлаарай.



- Зургийг ажиглаад, хөгжмөө сонсоорой.
- Хөгжимд аль зураг тохирох вэ? Яагаад?
- Сонссоноо хүний нүүрний хувирлаар илэрхийлж зурцгаая.
- Сонссон хөгжимдөө нэр өгөөрэй.





СОНОР ЧИХ (Тоглоом)

Тоглоомын заавар:

1. Тоглоомын удирдагч ямар нэг амьтны нэр хэлнэ. Тоглогчид тухайн амьтныг дуу авиагаар илэрхийлнэ.
2. Тоглоомын удирдагч ямар нэг амьтны дуу авиа гаргана. Тоглогчид сонсож таньснаа хөдөлгөөнөөр илэрхийлнэ.



- Тоглоомд гарсан дуу чимээнээс байгалийн үзэгдэл, амьтдын дуу чимээг ялгаж нэрлээрэй.
- Үлдсэн дуу чимээг юу гэж нэрлэх бол? Багштайгаа хамтран ярилцаарай.

Амьд байгалийн дуу чимээ	?
<ul style="list-style-type: none">- Хэрээ- Тахиа- Унага- Зөгий- Салхи	<ul style="list-style-type: none">- Цаг- Нисдэг тэрэг- Машин

ХӨГЖИМДЬЕ



Дасгал 1.

- Ямар ямар жимс байна вэ?
- Нэрлээд алга ташаарай.



Дасгал 2.

- Ямар хүнсний ногоо байна вэ? Дараах хүнсний ногоог нэрлээд алга ташаарай.
- Дээрх дасгалаас ямар ялгаатай байна вэ? Янз бүрийн дарааллаар нэрлэж алга ташаарай.



Дасгал 3.

- Зурагт үзүүлснээр хуруугаараа наадъя.
- Жигд хэмнэлээр тоолж, хэмжээгээ аваарай.
- Багшийн дохиог анхаарч нэгэн зэрэг гүйцэтгэнэ.





Цохилт тус бүрийг нэг хувь гэж нэрлэе.



Дасгал 4.

- Зургийг ажиглаарай.
- Алга ташиж нэрлээрэй.
- Хэдэн хувь байна вэ?

а.




б.




Дасгал 5.

- Зургийн дагуу алгаа ташиж, хөлөө товшиж тоглоё. Ингэхдээ багшийн дохиог анхаарч зэрэг эхлээрэй.





- Хөгжмийн энгийн зэмсэгтэй танилцаарай.



Савх мод




Шагшуурга



Бөмбөр



Товшвор



Хэц

- Хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөх аргатай танилцъя.






Дасгал 6.

- Сонирхсон хөгжмийн зэмсгээ сонгоорой.
- Сонгосон хөгжмийн зэмсгээрээ ижилсэж багт хуваагдаарай.
- Багшийнхаа дохиог анхаарч зургийн дагуу хөгжимдөгцгөө.




Дасгал 7.

- Багш, сурагч хоёрын бөмбөрийн цохилт ямар ялгаатай байна вэ?



Дасгал 8.

- Чи тоолж бас уншиж чадна. Зургийн дагуу тоолж алга ташаарай.



Хувь болгон урт богино цохилтоос бүтнэ.



БҮЖИГЛЭ

НАВЧИС (Хөгжимт хөдөлгөөн)

- Намрын модод навчсаа гээнэ.
- Навчсыг унагаахгүйгээр тэнцвэрээ хадгалж тоглоорой.



Навчис ганц нэгээрээ газарт уналаа.



Навчсыг түүж, дээш шидэж тоглоорой.



Навчсыг толгой дээрээ тавьж эргэлдээрэй.



Навчаа эрүүн дороо хавчуулаад эргээрэй.




Навчаа цээж болон нуруун дээрээ тавьж эргэлдээрэй.



Навчсыг дулаацуулж бүүвэйлээрэй.



Дараа намар дахин ирээрэй хэмээн навчсыг үдэж даллаарай.



ДАЛАЙ (Хөгжимт хөдөлгөөн)

- Хүүхдүүд ээ, далайн давалгааг дүрсэлж өөрийн дуртай хөдөлгөөнийг зохиомжилж бүжиглээрэй.



Голын ус жирэлзэнэ.



Голын ус цалгина.



Гол мөрөн далайд цутгана.



Далайн ус долгиолно.



Далай давалгаална.



Загаснууд далайдаа
наадна.



ЦЭВЭР ГАР (Хөгжимт хөдөлгөөн)

- “Цэвэр гар” дууны хэмнэлд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийцгээе.



Унтаж босоод гараа угаана даа
Шингэн савангаа хөөсрүүлж үрнэ дээ



Хичээл давтаад гараа угаана даа
Гэртээ очоод дүүдээ заана даа





Цэвэрхэн гартай боллоо доо

ЗОХИОН НАЙРУУЛЪЯ




Дасгал 1.

- Зураг дээрээс тэнгэрийн болон хүүхдийн төрх байдлыг ажиглаарай.
- Цаг агаар ямар байгааг тодорхойлцгооё.
- Хөгжмөө сонсоод тохирох байгалийн үзэгдлүүдийг дүрсэлж зураарай.



Дасгал 2.

- Анхааралтай сонсоорой. Юуны дуу чимээ вэ?
- Сонссон дуу чимээгээ доорх хэрэгслийг ашиглан дүрслээрэй.








Дасгал 3.

ҮЛГЭР ЗОХИОЁ

- Зургийг ажиглаад үлгэр зохион ярилцаарай.
- Амьтдын явдал алхааг дуурайн хөгжмийн энгийн зэмсгээс сонгон хөгжимдөөрэй.





Дасгал 4.

- Хөгжмийн энгийн зэмсгүүдээр бороог дүрслэн тоглоцгооё.



Дасгал 5.

- Зургийг ажиглаарай.

- Гарын доорх материал ашиглан дарааллын дагуу бөмбөр хийцгээе.




ӨӨРИЙГЭЭ СОРИОРОЙ



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Сонссон дарааллаараа дугаарлаарай.



- Анхааралтай сонсоорой.
- Найзынхаа тоглосон цохилтын тоог сонсож тодорхойлъё.
- Хэдэн хувь байна вэ?





Үг.О.Сундуй

ДУУЛҮЯ

Ая. С.Батболд

БИ ДУУЧИН

Дунд зэрэг

Аав-даа би Дуу дуулж өг - сөн Аав-даа би хайр-тай гэж дуул- сан
 Аа-вын-хаа өвөр дээр хүү-хэд бү - хэн Аз жар-гал-тай бай-даг гэж дуул - сан

Ээждээ би дуу дуулж өгсөн
Ээждээ би хайртай гэж дуулсан

Ээжийнхээ өвөр дээр хүүхэд бүхэн
Эрх жаргалтай байдаг гэж дуулсан

аав - даа - би хүү - хэд бү - хэн аа - вын - хаа

Үг. Л.Соронзонболд

Ая.С.Батболд

ДЭЛХИЙГЭЭ БИ МЭДНЭ

Хөнгөвтөр

Бөм - бөл-гөн бөө-рөн-хий хэл-бэр - тэй Дэл-гэр-хэн дэл-хий-гээ би мэд
 нээ Тив ч бий Да - лай ч бий Уулс ч бий ур - га-мал ч бий

Бөмбөлгөн бөөрөнхий хэлбэртэй
Дэлгэрхэн дэлхийгээ би мэднэ
Хот ч бий, тосгон ч бий
Үйлдвэр ч бий, уурхай ч бий

Бөмбөлгөн бөөрөнхий хэлбэртэй
Дэлгэрхэн дэлхийгээ би мэднэ
Дайнгүй тайван
Жаргалтай амьдаръя

3 хэмжээтэй.



Үг. Т.Галсан

Ая. С.Батболд

ХУВИРШГҮЙ ТООЛОЛ

Дунд зэрэг

8

Сүү-гээ хө-хүүл-сэн ээж минь хэд вэ? Хүү-гээ овог-ло-сон аав минь хэд
 вэ? Зөв-хөн ганц - даа ганц - даа Зүрх шиг ганц даа ганц - даа

Цэлмэг тэнгэр дээр нар нь хэд вэ?
Шөнийн одод дунд сар нь хэд вэ?

Над шиг нэг дээ нэг дээ
Нар шиг нэг дээ нэг дээ



Зөв-хөн ганц - даа ганц - даа

- Багшийнхаа дуулж, хөгжимдөхийг анхааралтай сонсоорой.
- Хэд хэдэн удаа давтаж дуулаарай.

Үг. Ая. Х.Ягаанцэцэг

МӨНХ НОГООН ГАЦУУР

Вальс

9

Хөн - гөн цас тэн-гэрт бү - жээд Хөв - чийн ойг цав-цайн хучи - хад
 Мөн - гөн өв - лийг чи-мэн ган - хаад Мөн - хийн ногоон_ га-цуур сайх - наа

Хүүхэд бидний хүслийг тээгээд
Хөвчийн ойг цавцайн хучихад
Мөнгөн өвлийг чимэн ганхаад
Мөнхийн ногоон гацуур сайхан аа

Цагаан цасан дээлээ тайлаад
Цэлгэр танхимд сүндэрлэлээ
Цэвцгэр ногоон гацууртайгаа
Цэнгэн жаргаж наадацгаая

- “Мөнх ногоон гацуур” дуундаа хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөөрэй.



3/4



СОНСЪЁ







- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хөгжмийн аялгуунд тохирох хөдөлгөөн хийгээрэй.
- Аль зураг тохиромжтой вэ? Яагаад?



МАРШ

- Зургийг ажиглаарай.
- Хөгжмөө сонсоод хэмнэлд тохируулан хурууныхаа өндгөөр зөөлөн тогшоорой.
- Эхний хувийг чанга, тод тогшино. >
- Хэмнэл өөрчлөгдсөн үү? Ямар хөдөлгөөн тохиромжтой вэ?




Марш бол алхахад тохиромжтой, жигд хэмнэлтэй, эрч хүч, урам зориг бадраасан хөгжим.



АМЬТДЫН МАРШ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Маршийн хэмнэлээр тогшоорой.




И.Штраус



ВАЛЬС

- Хөгжмөө анхааралтай сонсоод дөрөвт ноотоор хэмнэлийн хамсраа хийгээрэй.
- Эхний хувийг зүүн гараар, 2 ба 3 дахь хувийг баруун гараар гүйцэтгээрэй.



Вальс бүжиг $\frac{3}{4}$ хэмжээтэй.



Эхний хувь чанга 2 ба 3 дахь хувь сул байна.





ХӨГЖИМДЬЕ

ДӨРӨВТ НООТ



Дөрөвт
ноот
1 тоолно




- Дөрөвт ноотны хэмнэлээр хөгжимдье.





Дасгал 1.

- Баруун гарын хурууны дугаарыг нэрлэж дөрөвт ноотоор тоглоё.
- Дараа нь зүүн гараараа гүйцэтгээрэй. Гүйцэтгэхдээ багшийнхаа дохиог анхаарч жигд хэмнэлээр нэгэн зэрэг тоглоорой.




НАЙМТ НООТ



Наймт ноот

1 тоолоход
2 цохилт
байна.

1 и 1 и = 1 и



Hand clapping rhythm on a staff:

1 и 2 и | 1 и 2 и | 1 и 2 и | 1 и 2 и

Clapping rhythm on a staff:

1 и 2 и | 1 и 2 и | 1 и 2 и | 1 и 2 и

Дасгал 2.

- Дараах дасгалыг гүйцэтгэхдээ хурууны дугаарыг баримтлан ширээн дээр тогшоорой.
- Багшийн дохиог анхаарч зэрэг гүйцэтгээрэй.

а.


1 1 2 2 3 3 4 4 5 5

Эрхий мэргэн Эмч домч Дунд ноён Дугар зайсан Чигчий бүүвэй

б.

1 1 1 1 2 2 3 3 3 4 4 4 4 5 5 5 5

Эр-хий мэргэн Эмч домч Дунд но - ён Ду - гар зай - сан Чиг - чий бүү - вэй





Дасгал 3.

- Үгсийг үеэр таслан хэлж хэмнэлээр тогшоорой.

Аав	ээж	ах	эгч
Ө - вөө	э - мээ	хүр - гэн	бэр

А - жил	хий - вэл
Ам	тосод - но

Са - ваа	шан - дас
Ноос	мян - дас

Са - ваа шан - дас

Ноос мян - дас

Дасгал 4.

- Дасгалыг хэмнэлээр уншаад алгаа ташаарай.
- Үүссэн хэмнэлээ ноотонд шилжүүлж бичээрэй.
- Түргэн хэллэгийг тод чанга хэлнэ. (удаан, хурдан)

Жо - лоо	дар - даг
----------	-----------

Жо - роо	хал - тар
----------	-----------

Су - ран	жо - лоо
----------	----------

Ху - лан	жо - роо
----------	----------


Жо - лоо дар - даг


Су - ран жо - лоо







Дасгал 5.

- Дасгалыг гүйцэтгээрэй.



 түр зогсоно

 ноотны зогсоц 



Дасгал 6.

- Хэмнэлийг агаарт дүрсэлж үзүүлээрэй.

- Дүрсэлсэн хэмнэлээ ноотонд шилжүүлж бичээрэй.



Том

Жи - жиг


Том



Жи - жиг

Жи - жиг

Том





БҮЖИГЛЭЕ

АНГААХАЙ (Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн хэмнэлд тохируулан бяцхан ангаахайн хөдөлгөөнийг дүрсэлж дүрд хувирч тоглоорой.



Өндөг болоорой.



Хоёр тийшээ хөдлөөрэй.



Өндөг хагарлаа.



Бяцхан ангаахай
гарч ирлээ.



Ангаахай өд сөдөө
цэвэрлэнэ.



Эрүүгээ цэвэрлэнэ.



Цэвэрч ангаахай
гэдсээ цэвэрлэнэ.



Нуруугаа бас
цэвэрлэнэ.



Хөлөө өсгийгөөр нь
тавьж бүжиглэнэ.





АЛГА ТАШИЖ ТОГЛОЦГООЁ (Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн хэмнэлийг мэдэрч, алга ташиж тоглоцгооё.
- Хөдөлгөөнөө сайн сурсны дараа өөрсдийн сайн мэддэг дууны хэмнэлд тохируулан тоглоорой.



Өвдгөө цохино.



Алгаа ташина.



Баруун гараа солбиж ташина.



Дахин алгаа ташина.



Зүүн гараа солбиж ташина.



Алгаа ташина.





Хоёр гараа нийлүүлээд алгаа ташина.



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ





Дасгал 1.

- Тэмдгийн оронд ямар зэмсэг байх вэ? Янз бүрийн дараалалд оруулж хэмнэл зохиогоорой.



Дасгал 2.

- Зургийг ажиглаад шинж төрхийг ярилцаарай.
- Өгөгдсөн хэмжээнд зурагт тохирох хэмнэл зохиогоорой.
- Дүр бүтээж хөгжимдөөрэй.





Дасгал 3.

- Шагайг нэрлээд алга ташаарай.
- Шагай орхиж, янз бүрийн дараалалд оруулж хэмнэл зохиогоорой.

	Морь	Тэ мээ	Хонь	Я маа

--	--	--

Дасгал 4.

- Цохилтууд ямар ялгаатай байна вэ?
- Янз бүрийн зэмсэг сонгож сонирхолтой болгож найруулаарай.
- Өөрийн найруулсан бүтээлээ нөхөдтэйгөө хамтран хөгжимдөөрэй.

		?	?	?	?	?	?

Хүчтэй хувийг чанга тоглоно.

Дасгал 5.

ТУУЛАЙ, ЗАРАА ХОЁР

Зургийг ажиглаад, аялагчид сэдвээр
үлгэр зохиож ярилцаарай.
Тэдний алхаа хэрхэн өөрчлөгдсөн бэ?
Хөгжмөө анхааралтай сонсоод, тохирох
зургийг олоорой.



ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ




- Багшийгаа анхааралтай сонсоорой. Аль хэмнэлийг хөгжимдөж байна вэ?



- Хөгжмөө анхаарч сонсоорой. Дуу, бүжиг, маршийн аль нь вэ?



- Уншаад хэмнэлээр тогшоорой.
- Хэмнэлээ ноотоор бичээрэй.




Цэ-цэг навч

Цэн-хэр тал

Но-гоон зү-лэг

Но-мин тал

- Хөдөлгөөнийг зураглалын дагуу гүйцэтгээрэй.
- "Дэлхийгээ би мэднэ", "Би дуучин" дууг дуулъя. Ямар хэмжээтэй байна вэ?
- Ямар дуунд аль хөдөлгөөн тохиромжтой байна вэ?





ДУУЛЪЯ

Үг. Л.Соронзонболд

Ая. С.Батболд

ХИЧЭЭЛИЙН ЗАВСАРЛАГААНЫ ДУУТ БҮЖИГ

Дунд зэрэг

6

А-жил хий-гээд Ар-ван ху-руу яд-раа байл-гүй Тоо-гоо бод-соор

11

Тол-гой хү-зүү чи-лээ байл-гүй А-мар а-мар

Га-раа ам-раа Хө-дөл хө-дөл Хө-лөө ам-раа

Тонгойн суусаар
Тохой гар минь ядраа байлгүй
Хөдлөхгүй суусаар
Хоёр хөл минь чилээ байлгүй

Амар амар
Гараа амраа
Хөдөл хөдөл
Хөлөө амраа





ЭРДМИЙН ҮСЭГ СУРЛАА

Хөгжилтэй

6 Аа - ваа ха - раа - рай Ээ - жээ сон - соо - рой Ал - тан но - мын

үс - гийг би Ах шиг сайн сур - сан - даа аа - ваа а - хаа

10 Али - маа гэ - хэд А ор - дог тийм ээ аан тий - мээ тийм

Аав аа, хараарай
 Ээж ээ, сонсоорой
 Багшийн заасан үсгийг би
 Баттай сайн сурсан даа
 Нараа
 Найзаа
 Нааш ир гэхэд
 “На” ордог
 Тийм ээ? Аан
 Тийм ээ, тийм

Аав аа, хараарай
 Ээж ээ, сонсоорой
 Эрдэнэт номын үсгийг би
 Эгч шиг сайн сурсан даа
 Батаа
 Багшаа
 Баяртай гэхэд
 “Ба” ордог
 Тийм ээ? Аан
 Тийм ээ, тийм



- Тэмдэглэсэн хэсэгт анхааралтай дуулаарай.



тийм ээ аан тий - мээ тийм





БАГА АНГИЙН БАГШДАА БАЯРЛАЛАА

Дунд зэрэг

Ү - зэг барь - сан турь - хан гарг минь____ Үг хол - бох

ар - гыг____ заа - сан_____ Бага ан-гийн баг-шаа баяр - ла - лаа____

Бал-чир-хан би чинь би-чиж сур - лаа тай_____

Ухаан сорьсон бодлын санд минь
 Тоо бодох аргыг заасан
 Бага ангийн багшаа баярлалаа
 Балчирхан би чинь бодож сурлаа
 Үсэг таньсан саруул ойд минь
 Зөв унших аргыг заасан
 Бага ангийн багшаа баярлалаа
 Балчирхан би чинь уншиж сурлаа
 Аа - аа - аа
 Бага ангийн багшдаа би хайртай



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхаарч сонсоод зөв цэвэр дуулаарай.

санд минь _____

заа - сан _____

- Дуундаа дараах хэмнэлээр хамсраа хийж хөгжимдөөрэй.



Үг. Д.Лүндээжанцан

Ая. Б.Бямбабаяр

ДҮҮДЭЭ ХЭЛЖ ӨГНӨ ДӨӨ

Хурдавтар

7 Заан урт хо-шуу-тайг За-раа о-лон өр-гөс тэйг Та-хиа у-лаан за-лаа-тайг

12 Га - хай бү - дүүн хон-шоор-тойг Би мэ - дэж ав - лаа даа

— Дүү - дээ хэлж өг - нө - дөө Дүү - дээ хэлж өг - нө дөө

Муужгай урт сахалтайг
 Нохой хов хов дуутайг
 Тугал мөлгөр духтайг
 Туулай дэлдэн чихтэйг
 Би мэдэж авлаа даа

Дүүдээ хэлж өгнө дөө
 Дүүдээ хэлж өгнө дөө

Тэмээ ямар өндрийг
 Тэнгэр ямар уужмыг
 Нарны илч халууныг
 Надад ээж минь хайртайг
 Би мэдэж авлаа даа

Дүүдээ хэлж өгнө дөө
 Дүүдээ хэлж өгнө дөө

- Ноотыг нэрлээрэй.
- Хэмнэлээр хамсарч дуулаарай.
- Доорх хоёр дуу юугаараа ялгаатай байна вэ?



Заан урт хо - шуу- тайг За - раа о - лон өр - гөс - тэйг



Сүү - гээ хө - хүүл - сэн ээж минь хэд вэ?




СОНСЪЁ

С.Гончигсумлаа

МАРШ



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хэмнэлийг хурууны өндгөөр зөөлөн тогшоорой.
- Хэдэн хувь байна вэ?



С.Рахманинов



ПОЛЬКА



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хөгжмийн хэмнэлээр зөөлөн тогшоорой.
- Хэдэн хувь байна вэ?



Ц.Эрдэнэ

БҮҮВЭЙН ДУУ



- Багшийгаа анхааралтай сонсоод дагаад дуулаарай.
- Дуулахдаа ноотны дагуу хэмнэлээр тогшоорой.
- Хэдэн хувьт хэмжээ вэ?



- Дараах хоёр зохиолыг харьцуулан сонсьё.
- Аялгууны шинж төрх ямар байна вэ?
- Хэдэн хувьт хэмжээнд бичигдсэн байна вэ?
- Дуу, бүжиг, маршийн аль нь вэ?
- Ямар ялгаатай байна вэ?

Полька


- Хоёр хувьт хэмжээ
- Хөгжилтэй хөнгөн аялгуу
- Хурдан
- Бүжиг

Бүүвэйн дуу

- Хоёр хувьт хэмжээ
- Намуун зөөлөн аялгуу
- Удаан
- Дуу



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Торгууд ардын дуу “Агсал”, Захчин ардын “Бүүвэйн дуу”
- Аялгууг шинж төрхөөр нь дуу, бүжгийн аль нь болохыг тодорхойлоорой.
- Хэмнэлээр хамсран хөгжимдөөрэй.
- Хэдэн хувьт хэмжээ байна вэ?







Агсал

- Гурван хувьт хэмжээ
- Баатар зоригтой
- Тэмүүлэлтэй
- Дуут бүжиг

Бүүвэйн дуу

- Гурван хувьт хэмжээ
- Намуун тайван
- Удаан
- Дуу

- Хэмнэлээр тогшоорой.
- Дуу, бүжиг, маршид тохирох хэмнэлийг олоорой.







ХӨГЖИМДЬЕ

ХАГАС НООТ


Хагас
НООТ



2 тоолно.

- Зургийг анхааралтай ажиглаарай.
- Хоёр гараа урагш алдлан ширээн дээр байрлуулаарай.
- Зургийн дагуу дасгалыг гүйцэтгээрэй.





- Зураг дээрх хөгжмийн зэмсэг тус бүрээр баг болж хуваагдаарай.
- Зургийн дагуу хөгжимдөхдөө багшийн дохиог анхаараарай.

Дасгал 1.

3

Дасгал 2.

3

Дасгал 3.

3

3

Дасгал 4.


3

3





 - Хагас ноотны зогсоц 2 тоолно.

2










3











Дасгал 5.

- Зогсцын тэмдгийг ажиглаарай.
- Хэмнэлээр зөөлөн тогшоорой. Хэдэн хувьт хэмжээ вэ?

Дасгал 6.

- Хэмнэлээр тогшоорой.
- Хэдэн хувьт хэмжээ вэ?

БҮТЭН НООТ






Бүтэн
ноот

4 тоолно.





1 - 2 - 3 - 4

- Агаарт шулуун зурж дуулъя. Энэ шулууны урт 4 тоолж дуустал үргэлжилнэ. Дараагийн шулууныг 2 тоолж дуулаарай.




- 2 гараа ширээн дээр урагш алдлан байрлуулаарай.
- Зургийн дагуу дасгалыг гүйцэтгээрэй.
- Зургийг ноот бичлэгтэй харьцуулж ярилцаарай.



ноот дөрвөн нооттой тэнцэж байна.



○ - ─
 Бүтэн ноотны зогсоц 4 тоолно.



Дасгал 7.

- Хэмнэлийг ажиглаарай.
- Нийт хэдэн хувь болох вэ?

+ + =

+ + + + =

+ + + + =

Дасгал 8.

- Хэмнэлээр тогшоорой.
- Хэдэн хувьт хэмжээ вэ?



БҮЖИГЛЭЭ

ЦАСАН ХҮН (Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн олон янзын дүрслэлийг мэдэрч сэтгэл хөдлөлөө илэрхийлэн цасан хүн болж жүжиглэж тоглоорой.



Цасан хүн болоорой.



Цасан хүмүүс амь орж, таягаараа газар тогшин өвдгөө нугалахгүйгээр ойр ойрхон алхана.



Хоёр хөлийг ээлжлэн өсгийгөөр тавьж бүжиглээрэй.



Таягаараа мөс тогшоорой.




Таягаа мөрөндөө аваад алхаарай.



“Нар” гарлаа, цасан хүмүүс нэг нэгээрээ хайлан урсаж буй хөдөлгөөнийг дүрслээрэй.





ХҮҮХЭЛДЭЙ (Хөгжимт хөдөлгөөн)

- Үг. Д.Мандахсан, ая. Ш.Чинзориг “Хонхот хүүхэлдэй” дууны хэмнэлд тохируулан хөгжимт хөдөлгөөнөө гүйцэтгээрэй.



Хонхот хүүхэлдэй дуугаа дуулаад
Хоёр тийшээ найган ганхана



Жин жин жин жин жингэнээхэй
Бөн бөн бөндөгнөөхэй



Дон дон дон дон дон дон дон
Жин жин жин жин жин жин жин



БӨМБӨРЧИН (Хөгжимт хөдөлгөөн)

- Ая. С.Батболд “Наадацгаая” дууны аялгуу, хэмнэлд тохируулан бөмбөрөөр хөгжимдөж бүжиглэцгээе.



Бэлтгэх
байдал



Цохиураа
ээлжлэн өргөнө.



Хоёр тийш харж
бөмбөрөө дэлдээрэй.



Цохиураа хооронд
нь цохиорой.





Бөмбөрөө дэлдэцгээе нэг хоёр гурав дөрөв
Бүгдээрээ наадацгаая нэг хоёр гурав дөрөв



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ


Дасгал 1.

- Дүрсийг нэрлэж, талуудын тоог гарын дохиогоор илэрхийлж, нэгэн жигд хэмнэлээр тоглоё.
- Дүрсийг янз бүрийн дараалалд оруулж, өөрсдийнхөө анхаарал, хурдыг сорiorой.





Дасгал 2.

- Хэмнэлийг ажиглаарай.
- Багшийнхаа хөгжимдөхийг анхааралтай сонсоорой.
- Аль хэмнэлээр хөгжимдсэн бэ?



Дасгал 3.


- Хэмнэлээрээ хөгжимдөөрэй.
- Ямар ялгаа олж сонссон бэ?







Дасгал 4.

- Зургийг ажиглаарай.
- Хэмнэлээр тогшоорой.
- Тохирох хэмнэлийг сонгоод тайлбарлаарай.
- Ээждээ, эгчдээ бэлэглэх гоёмсог зүүлт хэлхээрэй.




Дасгал 5.

- Зургийн дагуу өөрсдөө хийж бүтээе.
- Өөрийнхөө бүтээсэн зэмсгээр хөгжимдөөрэй.




Дасгал 6.

- Шооны нүдэнд байрлах тоог ажиглая.
- Тоог нэгэн жигд хэмнэлээр уншиж хуруугаар илэрхийлж тоглоорой.



ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Зургийн дагуу өөрсдөө хөгжмийн энгийн зэмсэг хийж бүтээе.
- Өөрийнхөө бүтээсэн зэмсгээр доорх зураглалаар хөгжимдөөрэй.



$\frac{2}{4}$, $\frac{3}{4}$ хэмжээгээр “Товшоо” хөгжимт хөдөлгөөн зохиоцгооё.

Жишээ нь:

алга алга таш таш

өсгий өлмий ТОВШ ТОВШ



ДУУЛЪЯ

Үг. О.Сундуй

Ая. Б.Цэвээнсүрэн

ЯРГУЙ ДЭЛГЭРЛЭЭ

Тайван

7 Хай-руу хав-рын жав-ар сөр-өөд хам-гийн анх-ны яр-гуй дэл-гэр лээ_____

13 Тэн-гэр газ-рын ми-шээл тод-роод Эн-гэр бэл-ээр яр-гуй дэл-гэр - лээ_____

17 хүү - хэд бид - ний сэт - гэл шиг_____ хөх яр - гуй яар - саар ир - лээ

хүс-лийн цэн-хэр шу-вууд шиг хөх яр - гуй яар_саар - ир - лээ_____

Мөнгөн цасны сэтгэл уярааж
 Алтан нарнаас яргуй дэлгэрлээ
 Нутгаа санасан шувуу бүхний
 Нулимс гэмээр яргуй дэлгэрлээ

Дуулж үзээд ялгааг олоорой.

яр-гуй дэл-гэр яр - гуй дэл-гэр .

- Дууны утга агуулгыг ярилцаарай.
- Дараах хэмнэлээр хамсраа хийж дуулаарай.

$\frac{2}{4}$ Хайруу хаврын жавар сөрөөд хамгийн анхны яргуй дэлгэр - лээ _____

$\frac{2}{4}$



САЙН УУ, МУУ ЮУ АЛЬ НЬ ВЭ?

Дунд зэрэг

Өн-дөр нас-танд ту-сал-даг Өргө-сөн юм-ы нь дам-жил даг Са-наа тавьж

6 ту-сал-даг бол Сайн уу муу юу аль нь вэ хө Сайн сайн тэр бол сайн Сай-рх-даг-гүй бол

12 мун-даг сайн Тэт-гэж тус-лаж яв-даг бол Тэр л хүү-хэд маш сайн

Гэр орноо цэвэрлээд
 Сар гиймээр цэмцийлгээд
 Жаахан дүүгээ асардаг бол
 Сайн уу, муу юу аль нь вэ хө
 Сайн сайн тэр бол сайн
 Санаачилдаг бол мундаг сайн
 Цэвэрч нямбай сурсан бол
 Тэр л хүүхэд маш сайн

Тарьсан модыг хугалдаг
 Харсан бүгдийг эрээчдэг
 Сайран хамарлаж явдаг бол
 Сайн уу, муу юу аль нь вэ хө
 Аа, яа яа тэр тун муу
 Авир нь хэтрээд бүр ч муу
 Анхаарч засаж авахгүй бол
 Тэр л хүүхэд маш муу

Сурлага хичээлдээ шамдаад
 Урлаг наадамдаа шимтээд
 Сайхан хөөрхөн ааштай бол
 Сайн уу, муу юу аль нь вэ хө
 Сайн сайн тэр бол сайн
 Сахилгатай бол мундаг сайн
 Нөөц баялгаа арвилдаг бол
 Тэр л хүүхэд маш сайн



сай - рх даг - гүй бол
 са - наа чил - даг бол

маш - сайн



ШҮДЭЭ ХАЙРЛАЯ

Хурдавтар

5

Өг-лөө цай-гаа уус-ны да - раа Ү-дэш а-марч унт-хын өм__ нө

9

Амьд-ралд тус-лагч шү-дээ у-гаа-яа А-хин да - хин үү-нийг хэв-шүүл-ье

Түү - ний тулд__ оо хэ-рэг-тэй Тан-саг гоё - хон ф-тор той__ оо

Чихрийг багаар идэж байя
 Чихэргүй бохийг зажилж суръя
 Өнгөлөг сайхан цагаан шүдээ
 Өнөд дандаа арчилж явъя
 Түүний тулд
 Оо хэрэгтэй
 Тансаг гоёхон
 Фтортой оо

Насан багаас шүдээ угаая
 Нандин чухал заншил болгоё
 Яралзсан цэвэр шүдээ хайрлаж
 Ямагт дандаа эрүүл байлгая
 Түүний тулд
 Оо хэрэгтэй
 Тансаг гоёхон
 Фтортой оо



түү - ний тулд





СОНСЪЁ


- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хөгжмийн эхлэл хэсгийн хэмнэлээс чамд юу дүрслэгдсэн бэ?
- Зургийг ажиглаад, хөгжмийн дүрслэлд тохирохыг сонгоорой.
- Хөгжмөө сонсоод хэмнэлээр хөгжимдөөрэй.



ВАЛЬС

М.Глинка

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хэмнэлийн зураглалыг ажиглаад хэдэн хувь байгааг тодорхойлоорой.
- Хөгжимд тохирох хэмнэл аль нь вэ?
- Сонсоод хэмнэлийн хамсраа хийгээрэй.



ХӨГЖИМДЬЕ



Арван зургаат ноот


1 тоолоход 4 цохилт байна



1 и



- Дөрөвт болон арван зургаат ноотыг хурууны өндгөөр зөөлөн тогшиж харьцуулан ярилцаарай.



- Дараах хэмнэлээр эгшгийн цувааг өгсөх дарааллаар дуулаарай.
 - Өгсөх чиглэлд дуулах хүч ямар байх вэ?





Дасгал 3.

- Хэмнэлээр хөгжимдөөрэй.

Musical notation for Exercise 3, featuring two staves in 2/4 time. The top staff contains eighth notes, and the bottom staff contains quarter notes. Accompanying illustrations include drumsticks and a drum.

Дасгал 4.


- Хоёр хоолойгоор хөгжимдөөрэй. Хэмнэлээр алга ташихдаа зогсоцтой хэсгүүдийг анхаараарай.
- Хүчтэй хувийг тэмдэглээрэй.

Musical notation for Exercise 4, featuring two staves in 2/4 time. The top staff contains quarter notes, and the bottom staff contains quarter notes. Hand icons indicate hand positions, and squiggles above notes indicate dynamic changes.

Дасгал 5.

- Гурван хоолойгоор хөгжимдье. Зогсоцтой хэсгүүдийг анхаараарай.
- Хэдэн хувь байна вэ?
- Алга ташилтаас гадна дуртай хөгжмийн зэмсгээ сонгон хөгжимдөөрэй.

Musical notation for Exercise 5, featuring two staves in 3/4 time. The top staff contains quarter notes, and the bottom staff contains quarter notes. Hand icons indicate hand positions, and squiggles above notes indicate dynamic changes.





БҮЖИГЛЭЭ

Үг. Д.Амарсанаа

Ая. Б.Өнөржаргал



ШҮДЭЭ УГААЦГААЯ (Хөгжимт хөдөлгөөн)

- “Шүдээ угаацгаая” дууны хэмнэл, утга санаанд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийцгээе.



Оо, сойзоо бариарай.



Шүдээ угаахад бэлтгээрэй.



Оогоо сойзондоо түрхээрэй.



Наашаа цаашаа шир шир



Тойргоор угаая шир шир



Дээшээ доошоо шир шир



ЯРГУЙ ДЭЛГЭРЛЭЭ (Хөгжимт хөдөлгөөн)

- “Яргуй дэлгэрлээ” дууны утга санааг дүрслэн илэрхийлж хөдөлгөөн зохиомжлоорой.



Хайруу хаврын жавар сөрөөд
Хамгийн анхны яргуй дэлгэрлээ




Тэнгэр газрын мишээл тодроод
Энгэр бэлээр яргуй дэлгэрлээ



Хүүхэд бидний сэтгэл шиг
Хөх яргуй яарсаар ирлээ

Хүслийн цэнхэр шувуу шиг
Хөх яргуй яарсаар ирлээ



ХАВАР (Хөгжимт хөдөлгөөн)

- Хавар сэдвээр байгалийн үзэгдлийг дүрслэн бүжиглээрэй.



Цас хайлж хавар боллоо



Гол горхи гэслээ



Усны шувууд зэллэн нислээ



Загас усандаа шумбалаа



Салхи хүчтэй салхиллаа



Бороо шивэрч орлоо



Цэцэгс дэлбээгээ
дэлгэлээ




Урин дулаан болж
эрвээхэй эргэлдэн нислээ



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

Дасгал 1.


- Хэмнэлийн зураглалыг ажиглаарай. Хэдэн хувь бэ?
- Өгөгдсөн хэмжээнд байж болох утгыг олоорой.



Дасгал 2.


- Дүрсийг ажиглаад хэмнэлээр илэрхийлээрэй.
- Тод өнгийн дүрс хүчтэй хувийг бүдэг өнгийн дүрс сул хувийг илэрхийлнэ.
- Ноотонд шилжүүлж бичээрэй. Хэдэн хувь байна вэ?
- Хэмнэлээр хөгжимдөөд ямар дууны хэмнэл болохыг тодорхойлоорой.

- Маамуу нааш ир
- Гацуурхан



Дасгал 3.



















- Зургуудыг ажиглаад ярилцаарай.
- Зурагт тохирох хэмнэл зохиогоорой.
- Зохиосон хэмнэлээ хөгжимдөөрэй.
- Ямар зэмсэг тохиромжтой вэ?








Дасгал 4.




























- Хэмнэлээр бодлого бодъё.

 +  = 	 -  = 
 +  = 	 +  = 
 -  = 	 +  = 

Дасгал 5.

-    ноот ашиглан 2 ба 3 хувьт хэмжээнд хэмнэл зохиоё.

- Зохиосон хэмнэлээ хөгжмийн энгийн зэмсэг ашиглан тоглоорой.

$\frac{2}{4}$ 								
$\frac{3}{4}$ 								
$\frac{3}{4}$ 								

Дасгал 6.

- Өгөгдсөн хэмжээгээр айзмын зураас татаарай.

$\frac{2}{4}$ 								
--	---	---	---	---	---	--	---	---



ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ


- Онъсогыг уншаад, хэмнэлээр алга ташаарай.
- Хэмнэлээ ноотоор илэрхийлж бичээрэй.

 Дун	 ца -  гаан
Хар	ба - раан
Хурц	но - гоон
 Хон -  гор	 шар




Тэр юу вэ? (.....)

- Ноотыг нэрлээд үгийн сүлжээг бөглөөрэй.



Хэвтээгээр:





Босоогоор: 1. 

- Хэмнэлээр алга ташаарай.



- Шагайг нэрлээд хэмнэлээр алга ташаарай.



- Хэмнэлээр хөгжимдөөрэй.

